



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2016 оны 05 сарын 17 өдөр

Дугаар 159

Улаанбаатар хот

“Инвескор” ХХК-д банк бус санхүүгийн  
үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 22 дугаар зүйлийн 22.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 15 дугаар зүйлийн 15.3.1, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, Хорооны 2016 оны 71 дүгээр тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам”-ын 3.2 дах хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:


1. “Инвескор” ХХК-д банк бус санхүүгийн дараах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг тус тус олгосугай.

- 1.1 Зээлийн үйл ажиллагаа;
- 1.2 Факторингийн үйлчилгээ;
- 1.3 Итгэлцлийн үйлчилгээ;
- 1.4 Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хоронгө оруулалт хийх;
- 1.5 Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх.

2. Холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж ажиллахыг “Инвескор ББСБ” ХХК /Д.Баясгалан/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолыг олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /П.Алтан-Од/-т, Хорооны нэгдсэн бүртгэлд бүртгэхийг Бүртгэл, зөвшөөрлийн газар /Ю.Нэргүй/-т, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар /Б.Оюунцацрал/-т тус тус даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭХ  
ДЭД ДАРГА



Э.БАТБОЛД